



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2019 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А-160

Улаанбаатар хот

Төлбөрийн системийн тайлан
гаргах заавар батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ыг хавсралт ёсоор баталж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсүгэй.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А-92 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн картын журам”-д дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/ “14.8. Төлбөрийн карт гаргагч, хүлээн авагч банк нь “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын Хүснэгт 5-ын дагуу өөрийн салбар дээр хийгдсэн гүйлгээний тоон мэдээг ирүүлнэ.”

2/ “14.9. Тайланд тусгагдах гүйлгээний дүнг төгрөгөөр илэрхийлсэн байна. Төгрөгөөс бусад валютаар хийгдсэн гүйлгээний дүнг тайлант сар/улирлын сүүлийн өдрийн Монголбанкны ханшаар тооцож тайлагнана.”

3. “Төлбөрийн картын журам”-д дараах хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг:

“14.5. Карт гаргагч, хүлээн авагч нь картын үйл ажиллагааны тайланг сар тутам үнэн, зөв гаргаж, дараагийн сар бүрийн 10-ны өдрийн дотор Монголбанкинд “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын Хүснэгт 1, 2, 3, 4, 6-ын дагуу цахимаар ирүүлнэ.”;

2/ 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэг:

“14.6. Карт гаргагч, хүлээн авагч нь сар бүр гаргасан тайланг улирал тутам нэгтгэж дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор Монголбанкинд “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын Хүснэгт 1, 2, 3, 4, 6-ын дагуу албан бичгээр ирүүлнэ.”;

4. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А-93 дугаар тушаалаар баталсан “Хөдөлгөөнт банкны үйлчилгээний журам”-д дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

74 7278

Tushaal 2019.doc

1/ “2.2.12. Тайланд тусгагдах гүйлгээний дүнг төгрөгөөр илэрхийлсэн байна. Төгрөгөөс бусад валютаар хийгдсэн гүйлгээний дүнг тайлант улирлын сүүлийн өдрийн Монголбанкны ханшаар тооцож тайлагнана.”

5.“Хөдөлгөөнт банкны үйлчилгээний журам”-д дараах хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 2 дугаар зүйлийн 2.2.11 дэх хэсэг:

“2.2.11. Хөдөлгөөнт банкны үйлчилгээний тайлан, мэдээг “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын Хүснэгт 7, 8, 9, 10-д заасны дагуу улирал тутам гаргаж, дараа сарын 25-ны өдрийн дотор Монголбанкинд ирүүлэх.”;

6.Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А-263 дугаар тушаалаар баталсан “Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагааны журам”-д дараах хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг:

“10.2. Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгч нь өөрийн үйл ажиллагааны тайланг “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын Хүснэгт 11, 12, 13, 15-д заасны дагуу сар тутам үнэн зөв гаргаж, дараагийн сар бүрийн 10-ны өдрийн дотор Монголбанкинд цахим хэлбэрээр ирүүлнэ”;

2/ 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:

“10.3. Клирингийн системийн оператор нь өөрийн болон оролцогчийн үйл ажиллагааны доголдол, тасалдал, түүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын Хүснэгт 14.а, 14.б-д заасны дагуу сар тутам үнэн зөв гаргаж, дараагийн сар бүрийн 10-ны өдрийн дотор Монголбанкинд цахим хэлбэрээр ирүүлнэ”;

3/ 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг:

“10.4. Төлбөр тооцооны төлөөлөгч нь өөрийн оролцогчид төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангуулах зорилгоор зээл олгодог бол олгосон зээлийн тайланг “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын Хүснэгт 16-д заасны дагуу сар тутам үнэн зөв гаргаж, дараагийн сар бүрийн 10-ны өдрийн дотор Монголбанкинд цахим хэлбэрээр ирүүлнэ”;

7.Батлагдсан зааврыг мөрдөж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар), төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, клирингийн системийн оператор нарт тус тус даалгасугай.

8.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар), Дотоод аудитын газар (Т.Амарсайхан)-г тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2020 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А - 198

Улаанбаатар хот

Зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн А-160 тоот тушаалаар батлагдсан “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-т энэ тушаалын хавсралт 1-т заасан хэсгийг нэмсүгэй.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А-45 дугаар тушаалаар баталсан “Цахим мөнгөний журам”-ын дараах хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг:

“7.4. Үйлчилгээ эрхлэгч нь дараах тайлангуудыг дурдсан хугацаанд Монголбанканд ирүүлнэ.”

3. “Цахим мөнгөний журам”-д дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/ “7.4.1. Баталгааны дансны мэдээллийг “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын Хүснэгт 17-ын дагуу долоо хоног бүр үнэн, зөв гаргаж, дараа долоо хоногийн Лхагва гаригт багтаан цахим шуудангаар ирүүлнэ.”

2/ “7.4.2. Цахим мөнгөний хэрэглэгч, гүйлгээний тайланг “Төлбөрийн системийн тайлан гаргах заавар”-ын Хүснэгт 18, 19-ийн дагуу сар тутам үнэн, зөв гаргаж, дараагийн сар бүрийн 10-ны өдрийн дотор цахимаар ирүүлнэ.”

3/ “7.4.3. Сар бүр гаргасан тайланг улирал тутам нэгтгэж дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор албан бичгээр ирүүлнэ.”

4. Энэ тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар), цахим мөнгө гаргагч нарт тус тус үүрэг болгосугай.

5. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар), Дотоод аудитын газар (Т.Амарсайхан)-т тус тус даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

14 1149

Tushaal 2020.doc

Монголбанкны Ерөнхийлөгчийн
2019 оны 6 дугаар сарын 12-ний өдрийн
А-160 дугаар тушаалын хавсралт



ТӨЛБӨРИЙН КАРТ ГАРГАГЧ, ХҮЛЭЭН АВАГЧИЙН ИРҮҮЛЭХ ТАЙЛАН

Хүснэгт 1 – Картын тоон мэдээ

| № | Хот, аймаг | Картын нэр төрөл | | Картын төрөл | Картын тоо | Идэвхтэй ашиглагдаж буй карт | Идэвхтэй ашиглагдаж буй картын хувь |
|---|-------------|------------------|--------|--------------------|------------|------------------------------|-------------------------------------|
| | | ₮ карт | Энгийн | | | | |
| 1 | Улаанбаатар | ₮ карт | Энгийн | Дебит | | | |
| | | | | Кредит | | | |
| | | ... | Энгийн | Дебит | | | |
| | | | | Кредит | | | |
| | | | | ₮ карттай хосолсон | Дебит | | |
| | | Кредит | | | | | |
| 2 | Дархан-Уул | | | | | | |
| 3 | Орхон | | | | | | |
| 4 | Бусад аймаг | | | | | | |
| 5 | Нийт | | | | | | |

Хүснэгт 1-ийг нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|------------------|---|
| Хот аймаг | Картын тоон мэдээг тухайн картыг гаргасан хот, аймаг, сумын байршлаар нь Улаанбаатар, Дархан-Уул, Орхон, бусад аймаг гэсэн ангиллаар гаргана. |
| Картын нэр төрөл | Гаргаж буй картын төрөл тус бүрээр мөр нэмж тайлагнана (₮ карт, Виза, Мастеркарт, ЮнионПэй, ЖиСиБи, Амекс г.м). Тухайн картыг энгийн, ₮ карттай хосолсон гэж ангилна. |
| Картын төрөл | Гаргаж буй картыг дебит, кредит гэсэн төрлүүдэд хуваана. |
| Картын тоо | Картын төрөл тус бүрээр, ашиглагдаж байгаа буюу зөвхөн нээлттэй (open) төлөвт байгаа бүх картын тоон мэдээг тайлант сар/улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. Хаагдсан, түр хаагдсан, хэрэглэгчид хүлээлгэж өгөөгүй байгаа, идэвхгүй гэх мэт бусад төлөвт байгаа картын тоон мэдээг оруулахгүй. |

| | |
|-------------------------------------|---|
| Идэвхтэй ашиглагдаж буй карт | Сар бүр ирүүлэх тайланд тухайн сард 3 ба түүнээс дээш удаа үндсэн ба нэмэлт санхүүгийн гүйлгээ хийгдсэн нийт картын тоон мэдээг тайлагнана. Улирал бүр ирүүлэх тайланд тухайн улирлын 3 сарын дундаж дүнг тайлагнана. |
| Идэвхтэй ашиглагдаж буй картын хувь | Нийт картаас идэвхтэй ашиглагдаж буй картын эзлэх хувийг тайлагнана. |

Хүснэгт 2 – Карт хүлээн авагч төхөөрөмжийн тоон мэдээ

| № | Хот, аймаг | ПОС | МПОС | ПОБ | АТМ | СДМ | СРМ | Цахим худалдаа | КИОСК (пос-той) | Бусад |
|---|-------------|-----|------|-----|-----|-----|-----|----------------|-----------------|-------|
| 1 | Улаанбаатар | | | | | | | | | |
| 2 | Дархан-Уул | | | | | | | | | |
| 3 | Орхон | | | | | | | | | |
| 4 | Бусад аймаг | | | | | | | | | |
| 5 | Нийт | | | | | | | | | |

Хүснэгт 2-ыг нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|----------------------------|--|
| Хот аймаг | Карт хүлээн авагч төхөөрөмжийн тоон мэдээг Улаанбаатар, Дархан-Уул, Орхон, бусад аймаг гэсэн ангиллаар гаргана. |
| ПОС | Гэрээ байгуулан КҮБ-д байршуулсан, идэвхтэй ашиглагдаж буй нийт ПОС төхөөрөмжийн тоон мэдээг тайлант сар/улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. Процессор компанитай хамтран ажилладаг бол тухайн компаний байршуулсан ПОС-ын тоон мэдээг нэмж оруулна. |
| МПОС | КҮБ-тай гэрээ байгуулан байршуулсан, идэвхтэй ашиглагдаж буй нийт МПОС төхөөрөмжийн (ухаалаг гар утасны тусламжтайгаар, картаар идэвхжиж, гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгч) тоон мэдээг тайлант сар/улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |
| ПОБ | Банкны салбар нэгж дээр идэвхтэй ашиглаж буй нийт ПОБ төхөөрөмжийн тоон мэдээг тайлант сар/улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |
| АТМ | Зарлагын гүйлгээ хийх боломжтой нийт АТМ төхөөрөмжийн тоон мэдээг тайлант сар/улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |
| СДМ (cash deposit machine) | Орлогын гүйлгээ хийх боломжтой нийт АТМ төхөөрөмжийн тоон мэдээг тайлант сар/улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |
| СРМ (cash recycle machine) | Орлого, зарлагын гүйлгээ хийх боломжтой (recycle) нийт АТМ төхөөрөмжийн тоон мэдээг тайлант сар/улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |
| Цахим худалдаа | Цахим худалдааны онлайн КҮБ-ын нийт тоон мэдээг тайлант сар/улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |
| КИОСК (пос-той) | Өөртөө үйлчилж, үйлчилгээ авдаг, картаар төлбөр тооцоо хийх боломжтой төхөөрөмжийн тоон мэдээг тайлант сар/улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. (Жишээ нь ТҮЦ машин, кино театрын тасалбарын машин г.м) |

| | |
|-------|--|
| Бусад | Карт хүлээн авагч бусад төхөөрөмжийн тоон мэдээг тайлант сар/улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |
|-------|--|

Хүснэгт 3а –Өөрийн гаргасан картыг өөрийн сүлжээнд хүлээж авсан амжилттай гүйлгээний тайлан

| № | Хот, аймаг | ₮ карт | | ... | |
|---|-------------|--------|-----|-----|-----|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Улаанбаатар | | | | |
| 2 | Дархан-Уул | | | | |
| 3 | Орхон | | | | |
| 4 | Бусад аймаг | | | | |
| 5 | Нийт | | | | |

Хүснэгт 3а-г нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|------------|---|
| Хот, аймаг | Карт хүлээн авах төхөөрөмж байршиж буй хот, аймаг, сумын байршлаар нь Улаанбаатар, Дархан-Уул, Орхон, Бусад аймаг гэж ангилна. |
| ₮ карт | Тайлант сар/улиралд өөрийн гаргасан картыг өөрийн сүлжээнд хүлээн авсан нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг ирүүлнэ. Өөрийн гаргасан картын төрөл бүрээр багана нэмж ангилна. |

Хүснэгт 3б –Өөрийн гаргасан картаар хийгдсэн амжилттай гүйлгээний тайлан

| Хүлээн авагч төхөөрөмж | Нэгдсэн сүлжээ | | | | Гадаад сүлжээ | | | |
|------------------------|----------------|-----|-----|-----|---------------|-----|-----|-----|
| | ₮ карт | | ... | | Visa | | ... | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ПОС | | | | | | | | |
| ПОБ | | | | | | | | |
| АТМ | | | | | | | | |
| Цахим худалдаа | | | | | | | | |

Хүснэгт 3б-г нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|------------------------|---|
| Хүлээн авагч төхөөрөмж | Гүйлгээний тоон мэдээг хүлээн авсан төхөөрөмжийн төрлөөр буюу ПОС, ПОБ, АТМ, Цахим худалдаа гэж ангилж ирүүлнэ. |

| | |
|----------------|---|
| Нэгдсэн сүлжээ | Тайлант сар/улиралд өөрийн гаргасан картын гүйлгээг картын нэгдсэн сүлжээгээр дамжуулан (ҮЦГТ, бусад клирингийн төв) хүлээн авсан нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг ирүүлнэ. Өөрийн гаргасан картын төрөл бүрээр багана нэмж ангилна. |
| Гадаад сүлжээ | Тайлант сар/улиралд өөрийн гаргасан олон улсын картын гүйлгээг гадаад улсад хүлээн авсан нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг ирүүлнэ. Өөрийн гаргасан олон улсын картын төрөл бүрээр багана нэмж ангилна. |

Хүснэгт 4а –Өөрийн гаргасан картыг өөрийн сүлжээнд хүлээн авсан амжилттай гүйлгээний тайлан төхөөрөмж тус бүрээр

| № | Хот, аймаг | Өөрийн карт | | | | | | | | | | | | | | | | | |
|---|-------------|-------------|-----|------|-----|----------------|-----|---------|-----|-----------------|-----|-------|-----|-----|-----|-----------------|-----|----------------|-----|
| | | Бэлэн бус | | | | | | | | | | Бэлэн | | | | | | | |
| | | ПОС | | МПОС | | Цахим худалдаа | | ATM/CRM | | КИОСК (пос-той) | | ПОС | | ПОБ | | ATM/CRM зарлага | | CDM/CRM орлого | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Улаанбаатар | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2 | Дархан-Уул | | | | | | | | | | | | | | | | | | |
| 3 | Орхон | | | | | | | | | | | | | | | | | | |
| 4 | Бусад аймаг | | | | | | | | | | | | | | | | | | |
| 5 | Нийт | | | | | | | | | | | | | | | | | | |

Хүснэгт 4а-г нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|------------------------|--|
| Хот, аймаг | Карт хүлээн авах төхөөрөмж байршиж буй хот, аймаг, сумын байршлаар нь Улаанбаатар, Дархан-Уул, Орхон, Бусад аймаг гэж ангилна. |
| Өөрийн карт | Тайлант сар/улиралд өөрийн гаргасан картыг өөрийн сүлжээнд хүлээн авсан нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг ирүүлнэ. |
| Бэлэн бусаар хийгдсэн | Төхөөрөмжүүд дээр хийгдсэн бэлэн бус гүйлгээний мэдээллийг тайлагнана. |
| ПОС | ПОС төхөөрөмж дээр хийгдсэн санхүүгийн гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| МПОС | МПОС төхөөрөмж дээр хийгдсэн санхүүгийн гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| Цахим худалдаа | Цахим худалдааны онлайн КҮБ дээр хийгдсэн гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| ATM/CRM | ATM/CRM төхөөрөмж дээр хийгдсэн санхүүгийн гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| КИОСК (пос-той) | Киоск дээр хийгдсэн санхүүгийн гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| Бэлэн мөнгөөр хийгдсэн | Төхөөрөмжүүд дээр хийгдсэн бэлэн гүйлгээний мэдээллийг тайлагнана. |
| ПОС | ПОС төхөөрөмж дээр хийгдсэн бэлэн мөнгө олгох (cashback) гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| ПОБ | ПОБ төхөөрөмж дээр хийгдсэн бэлэн мөнгө олгох гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| ATM/CRM зарлага | ATM/CRM төхөөрөмж дээр хийгдсэн бэлэн мөнгөний зарлагын гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| CDM/CRM орлого | CDM/CRM төхөөрөмж дээр хийгдсэн бэлэн мөнгөний орлогын гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |

Хүснэгт 46 – Дотоодын бусад байгууллагын картыг өөрийн сүлжээнд хүлээн авсан амжилттай гүйлгээний тайлан

| № | Хот, аймаг | Дотоодын бусад байгууллагын карт | | | | | | | | | | | |
|---|-------------|----------------------------------|-----|------|-----|----------------|-----|-----------------|-----|-------|-----|-----------------|-----|
| | | Бэлэн бус | | | | | | | | Бэлэн | | | |
| | | ПОС | | МПОС | | Цахим худалдаа | | КИОСК (пос-той) | | ПОБ | | АТМ/CRM зарлага | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Улаанбаатар | | | | | | | | | | | | |
| 2 | Дархан-Уул | | | | | | | | | | | | |
| 3 | Орхон | | | | | | | | | | | | |
| 4 | Бусад аймаг | | | | | | | | | | | | |
| 5 | Нийт | | | | | | | | | | | | |

Хүснэгт 46-г нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|-------------------|---|
| Хот, аймаг | Карт хүлээн авах төхөөрөмж байршиж буй хот, аймаг, сумын байршлаар нь Улаанбаатар, Дархан-Уул, Орхон, Бусад аймаг гэж ангилна. |
| Бусад банкны карт | Тайлант сар/улиралд дотоодын бусад байгууллагын гаргасан картыг өөрийн сүлжээнд хүлээн авсан нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг ирүүлнэ. |
| Бэлэн бус | Төхөөрөмжүүд дээр хийгдсэн бэлэн бус гүйлгээний мэдээллийг тайлагнана. |
| ПОС | ПОС төхөөрөмж дээр хийгдсэн санхүүгийн гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| МПОС | МПОС төхөөрөмж дээр хийгдсэн санхүүгийн гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| Цахим худалдаа | Цахим худалдааны онлайн КУБ дээр хийгдсэн гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| КИОСК (пос-той) | Киоск дээр хийгдсэн санхүүгийн гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| Бэлэн | Төхөөрөмжүүд дээр хийгдсэн бэлэн гүйлгээний мэдээллийг тайлагнана. |
| ПОБ | ПОБ төхөөрөмж дээр хийгдсэн санхүүгийн гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| АТМ/CRM зарлага | АТМ/CRM төхөөрөмж дээр хийгдсэн бэлэн мөнгөний зарлагын гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |

Хүснэгт 4в – Гадаад байгууллагын гаргасан картыг өөрийн сүлжээнд хүлээн авсан амжилттай гүйлгээний тайлан

| № | Хот, аймаг | Гадаад байгууллагын карт | | | | | | | | | | | |
|---|-------------|--------------------------|-----|------|-----|----------------|-----|-----------------|-----|-------|-----|-----------------|-----|
| | | Бэлэн бус | | | | | | | | Бэлэн | | | |
| | | ПОС | | МПОС | | Цахим худалдаа | | КИОСК (пос-той) | | ПОБ | | АТМ/CRM зарлага | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Улаанбаатар | | | | | | | | | | | | |
| 2 | Дархан-Уул | | | | | | | | | | | | |
| 3 | Орхон | | | | | | | | | | | | |
| 4 | Бусад аймаг | | | | | | | | | | | | |
| 5 | Нийт | | | | | | | | | | | | |

Хүснэгт 4в-г нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|--------------------------|---|
| Хот, аймаг | Карт хүлээн авах төхөөрөмж байршиж буй хот, аймаг, сумын байршлаар нь Улаанбаатар, Дархан-Уул, Орхон, Бусад аймаг гэж ангилна. |
| Гадаад байгууллагын карт | Тайлант сар/улиралд гадаад байгууллагын гаргасан картыг өөрийн сүлжээнд хүлээн авсан нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг ирүүлнэ. |
| Бэлэн бус | Төхөөрөмжүүд дээр хийгдсэн бэлэн бус гүйлгээний мэдээллийг тайлагнана. |
| ПОС | ПОС төхөөрөмж дээр хийгдсэн санхүүгийн гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| МПОС | МПОС төхөөрөмж дээр хийгдсэн санхүүгийн гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| Цахим худалдаа | Цахим худалдааны онлайн КҮБ дээр хийгдсэн гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| КИОСК (пос-той) | Киоск дээр хийгдсэн санхүүгийн гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| Бэлэн | Төхөөрөмжүүд дээр хийгдсэн бэлэн гүйлгээний мэдээллийг тайлагнана. |
| ПОБ | ПОБ төхөөрөмж дээр хийгдсэн санхүүгийн гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| АТМ/CRM зарлага | АТМ/CRM төхөөрөмж дээр хийгдсэн бэлэн мөнгөний зарлагын гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |

Хүснэгт 5 – Төлбөрийн картаас бусад хэрэгсэл ашиглан банкны салбар дээр хийгдсэн гүйлгээний тоон мэдээ

| № | Төлбөрийн хэрэгсэл | | Бэлэн мөнгө | Кредит шилжүүлэг | Гуйвуулга | | | Гадаад шилжүүлэг /SWIFT/ |
|---|----------------------|-----|-------------|-------------------------|---------------|-----------|------------------------|--------------------------|
| | | | | | Western Union | Moneygram | Бусад мөнгөн гуйвуулга | |
| 1 | Илгээсэн гүйлгээ | Тоо | | | | | | |
| | | Дүн | | | | | | |
| 2 | Хүлээн авсан гүйлгээ | Тоо | | (тоон мэдээ оруулахгүй) | | | | |
| | | Дүн | | | | | | |

Хүснэгт 5-ыг нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|---|---|
| Төлбөрийн хэрэгсэл | Тайлант сар/улиралд банкны салбар дээр хийгдсэн нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг төлбөрийн хэрэгслээр ангилан тайлагнана. |
| Бэлэн мөнгө (илгээсэн) | Тайлант сар/улиралд харилцагч бэлэн мөнгө ашиглан өөрийн болон бусдын данс руу, банк дотроо болон банк хооронд шилжүүлэг хийсэн нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| Бэлэн мөнгө (хүлээн авсан) | Тайлант сар/улиралд харилцагч банк дотроо болон банк хооронд, өөрийн данснаас бэлэн мөнгө авсан нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| Кредит шилжүүлэг (илгээсэн) | Тайлант сар/улиралд харилцагч өөрийн данснаас бусдын данс руу, банк дотроо болон банк хооронд шилжүүлэг хийсэн нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| Гуйвуулга (илгээсэн) | Тайлант сар/улиралд Western Union, Moneygram, бусад мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглан илгээсэн нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| Гуйвуулга (хүлээн авсан) | Тайлант сар/улиралд Western Union, Moneygram, бусад мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглан хүлээн авсан нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| Гадаад шилжүүлэг /SWIFT/ (илгээсэн) | Тайлант сар/улиралд SWIFT ашиглан банкны салбараас харилцагчийн илгээсэн гадаад шилжүүлгийн нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| Гадаад шилжүүлэг /SWIFT/ (хүлээн авсан) | Тайлант сар/улиралд SWIFT ашиглан харилцагчийн бэлнээр болон харилцах, карт, хадгаламжийн дансанд хүлээн авсан гадаад шилжүүлгийн нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |

Хүснэгт 6 – Төлбөрийн картын залилангийн гүйлгээний тайлан (гаргагч, хүлээн авагч талаар)

| Байршил | Төхөөрөмж | Өөрийн гаргасан карт | | | | Дотоодын бусад банкны гаргасан карт | | | | Гадаадын байгууллагын гаргасан карт | | | |
|------------|----------------|----------------------|-----|-----|-----|-------------------------------------|-----|-----|-----|-------------------------------------|-----|-----|-----|
| | | ₮ карт | | ... | | ₮ карт | | ... | | Visa | | ... | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Монгол улс | ПОС | | | | | | | | | | | | |
| | МПОС | | | | | | | | | | | | |
| | АТМ/СRМ | | | | | | | | | | | | |
| | Цахим худалдаа | | | | | | | | | | | | |
| Олон улс | ПОС | | | | | (тоон мэдээ оруулахгүй) | | | | | | | |
| | АТМ/СRМ | | | | | | | | | | | | |
| | Цахим худалдаа | | | | | | | | | | | | |
| Нийт | | | | | | | | | | | | | |

Хүснэгт 6-г нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|-------------------------------------|---|
| Байршил | Тайлант хугацаанд шинээр гарсан залилангийн гүйлгээний тоон мэдээг ирүүлнэ. Залилангийн гүйлгээ гарсан байршлыг Монгол улсад, олон улсад гэж ангилна. |
| Төхөөрөмж (Монгол улс) | Тайлант сар/улиралд өөрийн суурилуулсан карт хүлээн авах төхөөрөмжүүд дээр хийгдсэн залилангийн гүйлгээний тоон мэдээг харгалзах нүдэнд тайлагнана. ПОС, МПОС, АТМ/СRМ, цахим худалдааны сайтаар хийгдсэн залилангийн гүйлгээний мэдээг ирүүлэх бөгөөд эдгээрээс өөр төхөөрөмж ашиглан хийгдсэн залилан гарсан тохиолдолд “бусад” гэсэн мөр нэмж болно. |
| Төхөөрөмж (Олон улс) | Тайлант сар/улиралд гадаад улсад хийгдсэн залилангийн гүйлгээний тоон мэдээг карт хүлээн авах төхөөрөмжөөр ангилж харгалзах нүдэнд тайлагнана. ПОС, МПОС, АТМ/СRМ, цахим худалдааны сайтаар хийгдсэн залилангийн гүйлгээний мэдээг ирүүлэх бөгөөд эдгээрээс өөр төхөөрөмж ашиглан хийгдсэн залилан гарсан тохиолдолд “бусад” гэсэн мөр нэмж болно. |
| Өөрийн гаргасан карт | Тайлант сар/улиралд өөрийн гаргасан картыг ашиглан өөрийн суурилуулсан карт хүлээн авах төхөөрөмжүүд дээр залилан хийгдсэн тохиолдолд Монгол улс хэсэгт харгалзах төхөөрөмжүүд дээр тоон мэдээг тайлагнана. Өөрийн гаргасан картыг ашиглан гадаад улсад хийгдсэн залилангийн гүйлгээний тоон мэдээллийг олон улс хэсэгт харгалзах төхөөрөмжүүд дээр тайлагнана. |
| Дотоодын бусад банкны гаргасан карт | Тайлант сар/улиралд дотоодын бусад байгууллагын гаргасан картыг ашиглан өөрийн карт хүлээн авах төхөөрөмжүүд дээр залилан хийгдсэн тохиолдолд Монгол улс хэсэгт, харгалзах төхөөрөмжүүд дээр тоон мэдээг тайлагнана. |

| | |
|-------------------------------------|---|
| Гадаадын байгууллагын гаргасан карт | Тайлант сар/улиралд гадаадын байгууллагын гаргасан картыг ашиглан өөрийн суурилуулсан карт хүлээн авах төхөөрөмжүүд дээр залилан хийгдсэн тохиолдолд Монгол улс хэсэгт, харгалзах төхөөрөмжүүд дээр тоон мэдээг тайлагнана. |
|-------------------------------------|---|

ХӨДӨЛГӨӨНТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ИРҮҮЛЭХ ТАЙЛАН

Хүснэгт 7 - Хөдөлгөөнт банкны хэрэглэгчийн тайлан

| № | Байршил | Интернет хандалт | | | Мобайл хандалт | | | Телефон банк | | | Нийт бүртгэлтэй цахим харилцагч |
|---|-------------|--------------------------------------|------|---------------|--------------------------------------|------|---------------|--------------------------------------|------|---------------|---------------------------------|
| | | Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн | Нийт | Нийт идэвхтэй | Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн | Нийт | Нийт идэвхтэй | Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн | Нийт | Нийт идэвхтэй | |
| 1 | Улаанбаатар | | | | | | | | | | |
| 2 | Дархан-Уул | | | | | | | | | | |
| 3 | Орхон | | | | | | | | | | |
| 4 | Бусад аймаг | | | | | | | | | | |
| 5 | Нийт | | | | | | | | | | |

Хүснэгт 7-г нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|--|---|
| Байршил | Хөдөлгөөнт банкны хэрэглэгчийг бүртгүүлсэн байршлаар нь Улаанбаатар, Дархан-Уул, Орхон, Бусад аймаг гэж ангилна. |
| Интернет хандалт | Интернэт протокол ашиглан (банкны цахим хуудас, гар утасны аппликейшн гэх мэт) хөдөлгөөнт банкны үйлчилгээ авч буй хэрэглэгчийн тоон мэдээг тайлант улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |
| Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн хэрэглэгч | Тайлант хугацаанд шинээр интернет хандалтын эрх авсан хэрэглэгчийн тоон мэдээг тайлант улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |
| Нийт хэрэглэгч | Интернет хандалтын эрхтэй нийт хэрэглэгчийн тоон мэдээг тайлант улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. Эрхээ түр хаалгасан, идэвхгүй байснаас болж эрхийг түр түдгэлзүүлсэн гэх мэт хэрэглэгчийн тоон мэдээг үүнд оруулахгүй. |
| Нийт идэвхтэй хэрэглэгч | Интернет хандалт ашиглан тайлант улирлын сар бүр 3 буюу түүнээс дээш удаа санхүүгийн гүйлгээ хийсэн хэрэглэгчийн тооны дундаж үзүүлэлтийг тайлагнана. (Жишээ нь эхний сар х, дараагийн сар у, сүүлийн сар z тооны идэвхтэй хэрэглэгч байсан бол нийт идэвхтэй хэрэглэгч нь $(x+y+z)/3$ байна) |
| Мобайл хандалт | USSD, SMS зэрэг үүрэн холбооны технологи ашиглан (мессеж, тусгай дугаар гэх мэт) хөдөлгөөнт банкны үйлчилгээ авч буй хэрэглэгчийн тоон мэдээг тайлант улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |
| Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн хэрэглэгч | Тайлант хугацаанд шинээр мобайл хандалтын эрх авсан хэрэглэгчийн тоон мэдээг тайлант улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |

| | |
|--|---|
| Нийт хэрэглэгч | Мобайл хандалтын эрхтэй нийт хэрэглэгчийн тоон мэдээг тайлант улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. Эрхээ түр хаалгасан, идэвхгүй байснаас болж эрхийг түр түдгэлзүүлсэн гэх мэт хэрэглэгчийн тоон мэдээг үүнд оруулахгүй. |
| Нийт идэвхтэй хэрэглэгч | Мобайл хандалт ашиглан тайлант улирлын сар бүр 3 буюу түүнээс дээш удаа санхүүгийн гүйлгээ хийсэн хэрэглэгчийн тооны дундаж үзүүлэлтийг тайлагнана. (Жишээ нь эхний сар x , дараагийн сар y , сүүлийн сар z тооны идэвхтэй хэрэглэгч байсан бол нийт идэвхтэй хэрэглэгч нь $(x+y+z)/3$ байна) |
| Телефон банк | Тусгай дугаарт холбогдон банкны үйлчилгээ авах буюу телефон банк ашиглан хөдөлгөөнт банкны үйлчилгээ авч буй хэрэглэгчийн тоон мэдээг тайлагнана. |
| Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн хэрэглэгч | Тайлант хугацаанд шинээр телефон банкны эрх авсан хэрэглэгчийн тоон мэдээг тайлант улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |
| Нийт хэрэглэгч | Телефон банкны эрхтэй нийт хэрэглэгчийн тоон мэдээг тайлант улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. Эрхээ түр хаалгасан, идэвхгүй байснаас болж эрхийг түр түдгэлзүүлсэн гэх мэт хэрэглэгчийн тоон мэдээг үүнд оруулахгүй. |
| Нийт идэвхтэй хэрэглэгч | Телефон банк ашиглан тайлант улирлын сар бүр 3 буюу түүнээс дээш удаа санхүүгийн гүйлгээ хийсэн хэрэглэгчийн тооны дундаж үзүүлэлтийг тайлагнана. (Жишээ нь эхний сар x , дараагийн сар y , сүүлийн сар z тооны идэвхтэй хэрэглэгч байсан бол нийт идэвхтэй хэрэглэгч нь $(x+y+z)/3$ байна) |
| Нийт бүртгэлтэй цахим харилцагч | Хөдөлгөөнт банкны үйлчилгээ ашиглаж буй нийт харилцагчийн давхардаагүй тоог тайлант улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. (интернет, мобайл, телефон банкны бүртгэлтэй хэрэглэгчийн давхардаагүй тоо. Жишээ нь нэг харилцагч интернет, мобайл, телефон банкны хандалтын эрхтэй бол 1 гэж тоолно). |

Хүснэгт 8 - Хөдөлгөөнт банкны гүйлгээний тайлан

| № | Төрөл/Суваг | Интернет хандалт | | | | Мобайл хандалт | | Телефон банк | |
|---|-----------------------------|--------------------|-----|-----------------------|-----|----------------|-----|--------------|-----|
| | | Цахим хуудас | | Гар утасны аппликейшн | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | | | |
| 1 | Банк дотор | | | | | | | | |
| 2 | Банк хооронд | | | | | | | | |
| 3 | Олон улсын гүйлгээ | | | | | | | | |
| 4 | Картын гүйлгээ | | | | | | | | |
| 5 | Зээл төлөлт | | | | | | | | |
| 6 | Төлбөр | Торгуулийн төлбөр | | | | | | | |
| | | Татвар төлөлт | | | | | | | |
| | | Гаалийн төлбөр | | | | | | | |
| | | Даатгал | | | | | | | |
| | | Хэрэглээний төлбөр | | | | | | | |
| | Бусад | | | | | | | | |
| 7 | Хөдөлгөөнт банкны процессор | | | | | | | | |
| 8 | Нийт | | | | | | | | |

Хүснэгт 8-ыг нөхөх заавар

| Мөр | Тайлбар (данснаас зарлага гаргасан талаар тоолно) |
|--------------------|--|
| Суваг | Хөдөлгөөнт банкны гүйлгээний тайланг сувгаар нь интернет хандалт, мобайл хандалт, телефон банк гэж ангилж ирүүлэх бөгөөд интернет хандалт ашиглан хийсэн гүйлгээг банкны цахим хуудсаар хийгдсэн, гар утасны аппликейшнээр хийгдсэн гэж тус тус ангилна. |
| Банк дотор | Интернет, мобайл, телефон банкны хандалт ашиглан тайлант улиралд, банкин дотроо илгээсэн нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг бөглөнө. |
| Банк хооронд | Интернет, мобайл, телефон банкны хандалт ашиглан тайлант улиралд, банк хооронд илгээсэн нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг бөглөнө. |
| Олон улсын гүйлгээ | Интернет, мобайл, телефон банкны хандалт ашиглан тайлант улиралд, олон улсад илгээсэн нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг бөглөнө. |
| Картын гүйлгээ | Интернет, мобайл, телефон банкны хандалт ашиглан картын гүйлгээ хийх боломжтой бол тайлант улиралт хийсэн картын гүйлгээний нийт тоон мэдээг бөглөнө. |
| Зээл төлөлт | Интернет, мобайл, телефон банкны хандалт ашиглан, тайлант улиралд, банкин дотроо зээлийн төлөлт хийсэн гүйлгээний нийт тоон мэдээг бөглөнө. |

| | |
|-----------------------------|---|
| Төлбөр | Интернет, мобайл, телефон банкны хандалт ашиглан банкин дотроо, төлбөр хийх тусгай цэс ашиглан торгуулийн төлбөр, татвар төлөлт, гаалийн төлбөр, даатгал, хэрэглээний болон бусад төлбөр төлөлт хийдэг бол нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг тайлагнана. Хэрэглээний төлбөр гэдэгт орон сууц, гар утас, кабель, цахилгаан зэрэг хэрэглээний төлбөрийг нэгтгэж, тоон мэдээг тайлагнана. Дээрх төрлүүдээс бусад төрлийн төлбөр хүлээн авдаг бол бусад гэсэн ангилалд гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| Хөдөлгөөнт банкны процессор | Most money, QRay гэх мэт хөдөлгөөнт банкны процессор ашиглан тайлант улиралд хийсэн нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг бөглөнө. |

Хүснэгт 9 – Гэрээт хамтрагчийн тайлан

| № | Байршил | Гэрээт хамтрагчийн тоо |
|---|-------------|------------------------|
| 1 | Улаанбаатар | |
| 2 | Дархан-Уул | |
| 3 | Орхон | |
| 4 | Бусад аймаг | |
| 5 | Нийт | |

Хүснэгт 9-ийг нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|------------------------|--|
| Байршил | Гэрээт хамтрагчийг бүртгүүлсэн байршлаар нь Улаанбаатар, Дархан-Уул, Орхон, Бусад аймаг гэж ангилна. |
| Гэрээт хамтрагчийн тоо | Банктай байгуулсан гэрээний үндсэн дээр тухайн банкны цахим хуудас, гар утасны аппликейшн зэргийг ашиглан өөрийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг борлуулж буй хувь хүн, хуулийн этгээдийн тоон мэдээг тайлагнана. Жишээ нь зарим үүрэн холбооны оператор, их дээд сургууль, интернет, кабелийн телевиз нь банктай гэрээ байгуулж, гар утасны аппликейшны төлбөр хэсэгт өөрийн байгууллагын дансны мэдээллийг оруулан, төлбөр тооцоог шууд хүлээн авах боломжтой байдаг. Эдгээр этгээдийг гэрээт хамтрагч гэж үзнэ. |

Хүснэгт 10 – Залилангийн болон хулгайн гүйлгээний тайлан

| Төрөл | Интернет хандалт | | | | Мобайл хандалт | | Бусад суваг | |
|---------------------|------------------|-----|----------------|-----|----------------|-----|-------------|-----|
| | Цахим хуудас | | Гар утасны апп | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | | | | |
| Залилангийн гүйлгээ | | | | | | | | |
| Хулгайн гүйлгээ | | | | | | | | |

Хүснэгт 10-ыг нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|------------------|---|
| Төрөл | Хэрэглэгчийн мөнгөн хөрөнгө болон нууцад хамаарах мэдээллийг эзэмших, захиран зарцуулах эрхгүй этгээд итгэл эвдэх буюу хуурч мэхлэх аргаар өөрийн эзэмшилд оруулж, учирсан хохирол нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр бол залилангийн гүйлгээ хэсэгт тоон мэдээг тайлагнана. Хэрэглэгчийн мөнгөн хөрөнгө болон нууцад хамаарах мэдээллийг эзэмших, захиран зарцуулах эрхгүй этгээд санаатайгаар, шунахайн зорилгоор, нууцаар өөрийн эзэмшилд оруулж, учирсан хохирол нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр бол хулгайн гүйлгээ хэсэгт тоон мэдээг тайлагнана. |
| Интернет хандалт | Залилан болон хулгайн аргаар хэрэглэгчийн мэдээллийг өөрийн эзэмшилд оруулж, интернет хандалтаар уг мэдээллийг ашиглан зөвшөөрөлгүй гүйлгээ хийсэн тоон мэдээг тайлагнана. Интернет хандалтаар хийгдсэн залиланг цахим хуудас, гар утасны аппликейшн гэж ангилна. |
| Мобайл хандалт | Залилан болон хулгайн аргаар хэрэглэгчийн мэдээллийг өөрийн эзэмшилд оруулж, мобайл хандалтаар уг мэдээллийг ашиглан зөвшөөрөлгүй гүйлгээ хийсэн тоон мэдээг тайлагнана. |
| Бусад суваг | Залилан болон хулгайн аргаар хэрэглэгчийн мэдээллийг өөрийн эзэмшилд оруулж, бусад сувгийн (телефон банк гэх мэт) хандалтаар уг мэдээллийг ашиглан зөвшөөрөлгүй гүйлгээ хийсэн тоон мэдээг тайлагнана. |

КЛИРИНГИЙН ТӨВИЙН ИРҮҮЛЭХ ТАЙЛАН

Хүснэгт 11 – Клирингийн системээр дамжсан гүйлгээ

| Систем | Амжилттай гүйлгээ | | Амжилтгүй гүйлгээ | | Үзүүлэлт |
|--------|-------------------|-----|-------------------|-----|----------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| | | | | | |

Хүснэгт 11-ийг нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|-------------------|---|
| Систем | Клирингийн системийн төрлийг тайлагнана (картын, бага дүнтэй төлбөрийн г.м). |
| Амжилттай гүйлгээ | Амжилттай гүйлгээ гэдэгт системээр амжилттай дамжсан гүйлгээний тоон мэдээг тайлагнана (харилцагч пин кодоо буруу оруулсан, дансны үлдэгдэл хүрэлцэхгүй байх зэрэг системийн бус алдаанаас болж амжилтгүй болсон гүйлгээг энд оруулна). |
| Амжилтгүй гүйлгээ | Амжилтгүй гүйлгээ гэдэгт системийн алдаанаас болж амжилтгүй болсон гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| Үзүүлэлт | $\text{Үзүүлэлт} = \frac{\text{Амжилттай гүйлгээний тоо}}{\text{Амжилттай гүйлгээний тоо} + \text{амжилтгүй гүйлгээний тоо}} * 100\%$ |

Хүснэгт 12 - Клирингийн системээр дамжсан амжилтгүй гүйлгээ

| Шалтгаан | Тоо | Дүн |
|----------|-----|-----|
| | | |
| | | |
| Нийт | | |

Хүснэгт 12-ыг нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|----------|--|
| Шалтгаан | Системийн алдаанаас болж амжилтгүй болсон гүйлгээнүүдийн амжилтгүй болсон шалтгаан, код (response code)-ыг тайлагнана. |
| Тоо | Амжилтгүй гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| Дүн | Амжилтгүй гүйлгээний дүнг тайлагнана. |

Хүснэгт 13 – Клирингийн системээр дамжсан оролцогч бүрийн гүйлгээ

| Оролцогчийн нэр | Илгээсэн гүйлгээний дүн | Илгээсэн гүйлгээний тоо ширхэг | Хүлээн авсан гүйлгээний дүн | Хүлээн авсан гүйлгээний тоо ширхэг |
|-----------------|-------------------------|--------------------------------|-----------------------------|------------------------------------|
| | | | | |
| Нийт | | | | |

Хүснэгт 13-ыг нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|------------------------------------|---|
| Оролцогчийн нэр | Клирингийн системийн оролцогчдын нэрийг тайлагнана. |
| Илгээсэн гүйлгээний дүн | Тухайн оролцогчийн амжилттай илгээсэн (үр дүнгийн тооцоололд орсон) нийт амжилттай гүйлгээний дүнг тайлагнана. |
| Илгээсэн гүйлгээний тоо ширхэг | Тухайн оролцогчийн амжилттай илгээсэн (үр дүнгийн тооцоололд орсон) нийт амжилттай гүйлгээний тоон мэдээг тайлагнана. |
| Хүлээн авсан гүйлгээний дүн | Тухайн оролцогчийн амжилттай хүлээн авсан (үр дүнгийн тооцоололд орсон) нийт амжилттай гүйлгээний дүнг тайлагнана. |
| Хүлээн авсан гүйлгээний тоо ширхэг | Тухайн оролцогчийн амжилттай хүлээн авсан (үр дүнгийн тооцоололд орсон) нийт амжилттай гүйлгээний дүнг тайлагнана. |

Хүснэгт 14а – Тасралтгүй ажиллагааны тайлан

| Нэр | Төлөвлөгөөт тасралт | Гэнэтийн тасралт | Нийт тасралт | Үзүүдэлт |
|-----|---------------------|------------------|--------------|----------|
| | | | | |
| | | | | |

Хүснэгт 14а-г нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|---------------------|--|
| Нэр | Клирингийн төв болон түүний оролцогчдын нэрийг тайлагнана. |
| Төлөвлөгөөт тасралт | Тайлант хугацаанд клирингийн төв болон түүний оролцогчдын үйл ажиллагаанд үүссэн төлөвлөгөөт тасралтын нийт хугацааг тайлагнана. |
| Гэнэтийн тасралт | Тайлант хугацаанд клирингийн төв болон түүний оролцогчдын үйл ажиллагаанд үүссэн гэнэтийн тасралтын нийт хугацааг тайлагнана. |
| Нийт тасралт | Тайлант хугацаанд клирингийн төв болон түүний оролцогчдын үйл ажиллагаанд үүссэн төлөвлөгөөт болон гэнэтийн тасралтын нийт хугацааг тайлагнана. |
| Үзүүдэлт | $\text{Үзүүдэлт} = \frac{\text{Тайлант хугацаанд ажиллах ёстой нийт хугацаа} - \text{Гэнэтийн тасралт үүссэн хугацаа}}{\text{Тайлант хугацаанд ажиллах ёстой нийт хугацаа}} * 100\%$ |

Хүснэгт 14б – Гэнэтийн тасралтын дэлгэрэнгүй тайлан

| Огноо | Нэр | Доголдол, тасалдлын шалтгаан | Үйл ажиллагаа тасалдсан хугацаа | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ/Тайлбар |
|-------|-----|------------------------------|---------------------------------|--------------------------------------|
| | | | | |
| | | | | |

Хүснэгт 14б-г нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|--------------------------------------|--|
| Огноо | Гэнэтийн тасралт үүссэн огноог тайлагнана |
| Нэр | Гэнэтийн тасралт үүссэн клирингийн төв/оролцогчийн нэрийг тайлагнана. |
| Доголдол, тасалдлын шалтгаан | Гэнэтийн тасралт үүссэн шалтгааныг тайлагнана. |
| Үйл ажиллагаа тасалдсан хугацаа | Тасралт үргэлжилсэн хугацааг тайлагнана. |
| Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ/Тайлбар | Гэнэтийн тасралт үүссэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлагнана. |

ТӨЛБӨР ТООЦООНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ИРҮҮЛЭХ ТАЙЛАН

Хүснэгт 15 – Төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагааны тайлан

| Оролцогчийн нэр | Төлбөр тооцооны нийт дүн | Хамгийн их дүнтэй төлбөр тооцоо | Төлбөр тооцооны дундаж дүн |
|-----------------|--------------------------|---------------------------------|----------------------------|
| | | | |
| | | | |
| Нийт | | | |

Хүснэгт 15-ыг нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|---------------------------------|--|
| Оролцогчийн нэр | Төлбөр тооцооны төлөөлөгчийн оролцогчдын нэрсийг тайлагнана. |
| Төлбөр тооцооны нийт дүн | Тайлант хугацаанд тухайн оролцогчийн хийсэн нийт төлбөр тооцооны дүнг тайлагнана. |
| Хамгийн их дүнтэй төлбөр тооцоо | Тайлант хугацаанд тухайн оролцогчийн хийсэн хамгийн их дүнтэй төлбөр тооцооны дүнг тайлагнана. |
| Төлбөр тооцооны дундаж дүн | Тайлант хугацаанд тухайн оролцогчийн хийсэн төлбөр тооцооны дундаж дүнг тайлагнана. |

Хүснэгт 16 – Зээл олголтын тайлан

| Зээл олгосон огноо | Зээлдэгчийн нэр | Зээлийн хэмжээ | Барьцаа хөрөнгийн нэр, төрөл | Зээл буцаан төлөгдсөн огноо |
|--------------------|-----------------|----------------|------------------------------|-----------------------------|
| | | | | |
| | | | | |

Хүснэгт 16-г нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|------------------------------|---|
| Зээл олгосон огноо | Оролцогчийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангуулах зорилгоор зээл олгосон огноог тайлагнана. |
| Зээлдэгчийн нэр | Зээлдэгчийн нэрийг тайлагнана. |
| Зээлийн хэмжээ | Зээлийн хэмжээг тайлагнана. |
| Барьцаа хөрөнгийн нэр, төрөл | Барьцаа хөрөнгийн нэр, төрлийг тайлагнана. |
| Зээл буцаан төлөгдсөн огноо | Зээл буцаан төлөгдсөн огноог тайлагнана. Буцаан төлөгдөөгүй байгаа тохиолдолд буцаан төлөх огноог тайлагнана. |



ЦАХИМ МӨНГӨ ГАРГАГЧИЙН ИРҮҮЛЭХ ТАЙЛАН

Хүснэгт 17 – Баталгааны дансны мэдээлэл

| | Огноо | Огноо | Огноо | Огноо | Огноо | Огноо | Огноо |
|-----------------------------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|
| Эргэлтэнд гарсан нийт цахим мөнгө | | | | | | | |
| Баталгааны дансны үлдэгдэл | | | | | | | |

Хүснэгт 17-г нөхөх заавар

| Мөр | Тайлбар |
|-----------------------------------|---|
| Эргэлтэнд гарсан нийт цахим мөнгө | Тухайн өдрийн эцсийн байдлаар эргэлтэнд гаргасан нийт цахим мөнгөний дүнг тайлагнана. |
| Баталгааны дансны үлдэгдэл | Тухайн өдрийн эцсийн байдлаар баталгааны дансны нийт үлдэгдлийг тайлагнана. |

Хүснэгт 18 – Цахим мөнгөний хэрэглэгчийн тайлан

| № | Төрөл | Тоо |
|---|---------------------------|-----|
| 1 | Шинэ хэрэглэгч | |
| 2 | Нийт бүртгэлтэй хэрэглэгч | |
| 3 | Нийт бүртгэлгүй хэрэглэгч | |
| 4 | Идэвхтэй хэрэглэгч | |
| 5 | Нийт хэрэглэгч | |
| 6 | Төлөөлөгч | |
| 7 | ЦМХА | |

Хүснэгт 18-г нөхөх заавар

| Мөр | Тайлбар |
|---------------------------|--|
| Шинэ хэрэглэгч | Нийт шинэ хэрэглэгчийн тоон мэдээг тайлант сар/улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |
| Нийт бүртгэлтэй хэрэглэгч | Үйлчилгээ эрхлэгчтэй гэрээ байгуулсан бүртгэлтэй хэрэглэгчийн тоон мэдээг тайлант сар/улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |
| Нийт бүртгэлгүй хэрэглэгч | Нийт бүртгэлгүй хэрэглэгчийн тоон мэдээг тайлант сар/улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |
| Идэвхтэй хэрэглэгч | Сар бүр ирүүлэх тайланд тухайн сард 3 ба түүнээс дээш удаа цахим мөнгөний зарлагын гүйлгээ хийсэн хэрэглэгчийн тоон мэдээг тайлагнана. Улирал бүр ирүүлэх тайланд тухайн улирлын 3 сарын дундаж дүнг тайлагнана. |
| Нийт хэрэглэгч | Нийт хэрэглэгчийн (бүртгэлтэй, бүртгэлтгүй) тоон мэдээг тайлант сар/улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |
| Төлөөлөгч | Нийт төлөөлөгчийн тоон мэдээг тайлант сар/улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |
| ЦМХА | Нийт цахим мөнгө хүлээн авагчийн тоон мэдээг тайлант сар/улирлын сүүлийн өдрийн байдлаар тайлагнана. |

Хүснэгт 19 – Цахим мөнгөний гүйлгээний тайлан

| Төрөл | ЦМХА | Төлөөлөгч | | | Хэрэглэгч | | | | |
|----------------|--|-----------------------|--|--|-----------------------|--|--|---------------------------------------|---------------------------------------|
| | Бараа, үйлчилгээний төлбөр хүлээн авах | Цахим мөнгө шилжүүлэх | Цахим мөнгийг мөнгөн хөрөнгөнд хөрвүүлэх | Мөнгөн хөрөнгийг цахим мөнгөнд хөрвүүлэх | Цахим мөнгө шилжүүлэх | Цахим мөнгийг бусад оролцогчийн данс руу шилжүүлэх | Бусад оролцогчийн данснаас цахим мөнгөний данс руу шилжүүлэх | Цахим мөнгийг бэлэн мөнгөнд хөрвүүлэх | Бэлэн мөнгийг цахим мөнгөнд хөрвүүлэх |
| Гүйлгээний тоо | | | | | | | | | |
| Гүйлгээний дүн | | | | | | | | | |

Хүснэгт 19-г нөхөх заавар

| Багана | Тайлбар |
|---|---|
| Бараа, үйлчилгээний төлбөр хүлээн авах | Тайлант сар/улиралд худалдаа, үйлчилгээний байгууллага (merchant) цахим мөнгөөр бараа, үйлчилгээний төлбөр хүлээн авсан гүйлгээний нийт тоо, дүнг тайлагнана. |
| Төлөөлөгчөөр дамжуулан цахим мөнгө шилжүүлэх | Тайлант сар/улиралд төлөөлөгчөөр дамжуулан цахим мөнгөний данснаас цахим мөнгөний данс руу шилжүүлсэн гүйлгээний нийт тоо, дүнг тайлагнана. |
| Төлөөлөгчөөр дамжуулан цахим мөнгийг мөнгөн хөрөнгөнд хөрвүүлэх | Тайлант сар/улиралд төлөөлөгчөөр дамжуулан хэрэглэгч өөрийн цахим мөнгийг мөнгөн хөрөнгөнд хөрвүүлсэн гүйлгээний нийт тоо, дүнг тайлагнана. |
| Төлөөлөгчөөр дамжуулан мөнгөн хөрөнгийг цахим мөнгөнд хөрвүүлэх | Тайлант сар/улиралд төлөөлөгчөөр дамжуулан хэрэглэгч мөнгөн хөрөнгийг цахим мөнгөнд хөрвүүлсэн гүйлгээний нийт тоо, дүнг тайлагнана. |
| Хэрэглэгч цахим мөнгө шилжүүлэх | Тайлант сар/улиралд хэрэглэгч өөрийн цахим мөнгөний данснаас бусдын цахим мөнгөний данс руу цахим мөнгө шилжүүлсэн гүйлгээний нийт тоо, дүнг тайлагнана. |
| Хэрэглэгч цахим мөнгийг бусад оролцогчийн данс руу шилжүүлэх | Тайлант сар/улиралд хэрэглэгч өөрийн цахим мөнгөний данснаас банкны болон төлбөрийн системийн бусад оролцогчийн данс руу шилжүүлсэн гүйлгээний нийт тоо, дүнг тайлагнана. |
| Хэрэглэгч бусад оролцогчийн данснаас | Тайлант сар/улиралд хэрэглэгч банкны болон төлбөрийн системийн бусад оролцогчийн данснаас цахим мөнгөний данс руу шилжүүлсэн гүйлгээний нийт тоо, дүнг тайлагнана. |

| | |
|---|---|
| цахим мөнгөний данс руу шилжүүлэх | |
| Хэрэглэгч цахим мөнгийг бэлэн мөнгөнд хөрвүүлэх | Хэрэглэгч цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэгчийн салбар, нэгж дээр өөрийн биеэр очиж эсвэл цахим мөнгө гаргагчаас байршуулсан цахим мөнгө хөрвүүлэх төхөөрөмж /төлөөлөгч дээр байршуулсан төхөөрөмжөөс бусад/ ашиглан өөрийн цахим мөнгийг бэлэн мөнгөнд хөрвүүлсэн гүйлгээний нийт тоо, дүнг тайлагнана. |
| Хэрэглэгч бэлэн мөнгийг цахим мөнгөнд хөрвүүлэх | Хэрэглэгч цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэгчийн салбар, нэгж дээр өөрийн биеэр очиж эсвэл цахим мөнгө гаргагчаас байршуулсан цахим мөнгө хөрвүүлэх төхөөрөмж /төлөөлөгч дээр байршуулсан төхөөрөмжөөс бусад/ ашиглан бэлэн мөнгийг цахим мөнгөнд хөрвүүлсэн гүйлгээний нийт тоо, дүнг тайлагнана. |